

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

Санамж: Хариултын хуудасны заавартай сайтар танилцаарай.

- Энэ хэсэг нь 40 сонгох даалгавар, нийт 80 оноотой.
- Даалгавар бүр 5 сонгох хариулттай бөгөөд зөвхөн нэг хариулт сонгоорой.
- Сонгосон хариултаа хариултын хуудсанд будаж тэмдэглээрэй.
- Эхийг анхааралтай уншиж ойлгоод, даалгаврыг гүйцэтгээрэй.
- 1-13 дугаар сорилыг эхийн утга санаатай холбон ажиллаарай.

Аугаа их тоо “Нэг” /эсээ/

Бидний оршин буй ертөнц нэг. Нар нэг, Сар нэг, Алтан гадас, Үүрийн цолмон, Өмнөд хаалган... цөм нэг, нэг. Ав адилхан хоёр юм гэж орчлон хорвоод үгүй. Үгүйн учир гэвэл ижилхэн үйлийн үр бүхий амьтан ургамал, үзэгдэл юмс байдаггүй. Бүгд урьд өмнө дамжсан тоо томшгүй төрөл, төрөл тутамдаа амссан өөр өөр зовлон, үйлдсэн өөр өөр үйлийн эрхээр өвөр зуураа огт адилгүй үйлийн үрийг бүтээж, энэхүү өвөр хоорондоо адилгүй үйлийн үр нь онд ондоо шалтгаан нөхцөлд өөр хоорондоо адилгүйгээр шүтэн барилдаж бүтдэг учраас бүхий л амьтан ургамал, үзэгдэл юмс ганц. Ганц гэгч чанар. Ганцын чанараас илүү дээд чанар гэж үгүй бөгөөд дээд чанар учраас ганцаас илүү аугаа нь үгүй бөлгөө.

Аливаа амьтан ургамал нь ганц ганц учраас ганцаардлын айдастайгаар төрдөг. Айдас бол тэдний хувь тавилан. Сэтгэлийнх нь сүүдэр. Чухамхүү айдсын ачаар амьдралын төлөө тэмцэж, айдсынхаа хүчинд оршиж байдаг боловч айдсаасаа болоод хань ижлийг хайж, хань ижил олж, олсноор сүрэглэн явмагцаа ганцаардлын чанар буюу дээд чанараа алддаг. Ганцаардалтай тэмцсэн тэмцэл нь хүн төрөлхтөнд өөр шүтлэгийг авчирчээ. Эрт цагт нэг мөнх хөх тэнгэр, нэг нар, нэг сар, нэг хангарди гэхчлэн үндэстэн ястан өөр хоорондоо ондоо ондоо хүчтэнийг шүтдэг байснаа болин, тооны олонд шүтэн, олныг хайх, олныг олох, олныг эзэмшихийн төлөө тэмцэх болсноор эдүгээгийн хүмүүний амьдралын утга учир нь их тоо болжээ. Орчлон ертөнцөд амьдрахынх нь утга төгс төгөлдөрт тэмүүлэх хүслийг нь тоо эзэмдэн, тархи толгойд нь сая сая тоо эргэлдэн, тэрбум живаагийн зүг хүн тэмүүлэх болжээ. Тооны олонд шунах шуналаас болж бие биеэ хөнөөж, бие биеэ эзлэн түрэмгийлнэ. Тооны олноор зэрэг хэргэм, алдар нэрийг олж, тооны олноос болж алтан амьсүйдэж, ариун нандин бузарлагдах авч бүгд тооны олон руу улангасна.

Хүмүүний ертөнц тоонд толгойгоо мэдүүлжээ. Аугаа хүнд захирагддаг байсан ертөнц их тоонд захирагддаг болжээ. “Их тоонд захирагддаг болсноор тоо олшрохыг хөгжил юм” гэж үзэн, бүхнийг тооны аргаар бүтээж, бүхнийг тооны олон захирна. Төрийн жолоог ч олноор атган, хааш хэрхэн залахыг ч тооны олон шийднэ.

Үнэн худлыг ч тооны олноор ялган, өршөөх цаазлахыг ч тооны олноор шийднэ. Олон бол үнэн. Олонхын үнэн хэмээсэн нь хэнд ч няцаагдашгүй.

Олонх түүнийг үнэн гэсэн учраас худал байсан ч үнэн. Үнэн гэж үгүй учраас ертөнцөд хүчтэй нь гагцхүү их тоо. **Их тооны энэхүү дарангуйлал нь хувь хүнийг сүрэгт татан оруулснаар хүн төрөлхтөн нэгэн их сүрэг болж, ертөнцөд гагцхүү сүргийн сэтгэлгээ буюу их тооны сэтгэлэг ноёрхож, энэхүү их тооны сэтгэлэг нь мөнөөх нэг нар, нэг сар, нэг алтан гадас, үүрийн цолмон, өмнөд хаалганы одыг ч өөрийн сүрэгт оруулах болно. Тэр цагт нэг гэдэг ертөнцийн аугаа их тоо үгүй болно.**

Д.Батбаяр



1. Үгийг утгаар нь зөв харгалзуулсан хэсгийг олоорой.

1) шүтэх	a. улайран дайрах
2) сүрэглэх	b. хүсэн дурлах
3) улангасах	c. хэсгээрээ бөөгнөрөх
4) тэмүүлэх	d. гүнээ итгэх
5) ноёрхох	e. эзэрхэн захирах

A. 1d, 2c, 3a, 4e, 5b B. 1d, 2c, 3a, 4b, 5e C. 1b, 2c, 3a, 4d, 5e
D. 1b, 2a, 3c, 4d, 5e E. 1d, 2c, 3e, 4a, 5b
2. “Аливаа амьтан ургамал нь ганц ганц учраас ганцаардлын айдастайгаар төрдөг” гэсэн толгой өгүүлбэрийг дэмжих өгүүлбэр аль нь вэ?
 - A. Их тоонд захирагддаг болсноор тоо олшрохыг хөгжил хэмээн үзэж, бүхнийг тооны аргаар бүтээж, бүхнийг тооны олон захирна.
 - B. Чухамхүү айдсын ачаар амьдралын төлөө тэмцэж, айдсынхаа хүчинд оршиж байдаг.
 - C. Олон бол үнэн. Олонхын үнэн хэмээсэн нь хэнд ч няцаагдашгүй.
 - D. Нар нэг, Сар нэг, Алтан гадас, Үүрийн цолмон, Өмнөд хаалган... цөм нэг, нэг. Ав адилхан хоёр юм гэж орчлон хорвоод үгүй.
 - E. Тэр цагт нэг гэдэг ертөнцийн аугаа их тоо үгүй болно.
3. Эсээний хөтөч санаа аль вэ?
 - A. Бидний оршин буй ертөнц нэг. Нар нэг, Сар нэг, Алтан гадас, Үүрийн цолмон, Өмнөд хаалган... цөм нэг, нэг.
 - B. Ав адилхан хоёр юм гэж орчлон хорвоод үгүй. Үгүйн учир гэвэл ижилхэн үйлийн үр бүхий амьтан ургамал, үзэгдэл юмс байдаггүй.
 - C. Ганц гэгч чанар. Ганцын чанараас илүү дээд чанар гэж үгүй бөгөөд дээд чанар учраас ганцаас илүү аугаа нь үгүй бөлгөө.
 - D. Бүгд урьд өмнө дамжсан тоо томшгүй төрөл, төрөл тутамдаа амссан өөр өөр зовлон... үйлийн үрийг бүтээдэг.
 - E. ... энэхүү өвөр хоорондоо адилгүй үйлийн үр нь онд ондоо шалтгаан нөхцөлд шүтэн барилдаж бүтдэг учраас бүхий л амьтан ургамал, үзэгдэл юмс ганц.
4. “Тэр цагт нэг гэдэг ертөнцийн аугаа их тоо үгүй болно” гэсний учир юу вэ?
 - A. Ав адилхан хоёр юм гэж орчлон хорвоод үгүй учраас
 - B. ... ижилхэн үйлийн үр бүхий амьтан ургамал, үзэгдэл юмс байдаггүй учраас
 - C. Хүмүүний ертөнц тоонд толгойгоо мэдүүлсэн учраас
 - D. Их тооны дарангуйлал ертөнцийг сүргийн сэтгэлгээтэй болгох учраас
 - E. Аливаа амьтан ургамал нь ганц ганц учраас
5. Эхэд дэвшүүлсэн асуудал аль нь вэ?
 - A. Хорвоогийн юмс бүхэн ганц байдаг тухай
 - B. Ганцаардлаас айдас үүсдэг тухай
 - C. Ганц гэдэг үнэ цэнт чанар алдагдаж байгаа тухай
 - D. Ганц гэдэг туйлын дээд чанар болох тухай
 - E. Их тоо ноёрхож байгаа тухай
6. Эхийн гол санааг илэрхийлэх түлхүүр өгүүлбэрийг олоорой.
 - A. Бүхий л амьтан ургамал, үзэгдэл юмс ганц.
 - B. Ганцын чанараас илүү дээд чанар гэж үгүй.
 - C. Аливаа амьтан ургамал ганцаардлын айдастай төрдөг.
 - D. Хүмүүний ертөнц тоонд толгойгоо мэдүүлжээ.
 - E. Аугаа хүнд захирагддаг байсан ертөнц их тоонд захирагддаг болжээ.



7. Эхийн онцолсон хэсгийн хэв маягийг зөв тодорхойлсон нь аль вэ?
- A. Их тоо нь багыгаа эрхэндээ хэрхэн оруулдгийг учир зүйн дэс дараатай өгүүлж, тоочсон тул тоочимж, хүүрнэмж хосолсон
 - B. Их тоо нь багыгаа эрхэндээ хэрхэн оруулдаг тухай нэгэн цагт зэрэгцүүлэн тоочсон тул тоочимж
 - C. Их тоо нь багыгаа эрхэндээ хэрхэн оруулдгийг учир зүйн дэс дараатай өгүүлсэн тул хүүрнэмж
 - D. Их тоо нь багыгаа эрхэндээ хэрхэн оруулдаг учир шалтгааныг тайлбарлан мэдээлсэн тул тайлбарламж
 - E. Их тоо нь багыгаа эрхэндээ хэрхэн оруулдаг талаар оюун дүгнэлт гарган бичсэн тул эргэцүүлэмж
8. “Тооны олноор зэрэг хэргэм, алдар нэрийг олж, тооны олноос болж алтан амьсүйдэж, ариун нандин бузарлагдах авч бүгд тооны олон руу улангасна” гэсэн өгүүлбэрт ямар уран хэрэглүүр байна вэ?
- A. төстэй хэлбэрээр, тэгш эрхтэйгээр зэрэгцүүлсэн тул зэрэгцүүлэл
 - B. ижил төстэй үгсийг сөөлжүүлэн, салаавчлан бичсэн тул сөөлжүүлэл
 - C. санаагаа аажмаар өсгөн дүрсэлж, хүч нэмсэн тул ахиулал
 - D. эсрэг тэсрэг зүйлсийг сөргөцүүлэн дүрсэлсэн тул харшуулал
 - E. сэтгэлийн өнгө аяс, санаагаа гаргахдаа урнаар асуусан тул уран асуулт
9. Аль нь хэлц өгүүлбэр вэ?
- A. Хүмүүний ертөнц тоонд толгойгоо мэдүүлжээ.
 - B. Олонхын үнэн хэмээсэн нь хэнд ч няцаагдашгүй.
 - C. Ав адилхан хоёр юм гэж орчлон хорвоод үгүй.
 - D. Олонх түүнийг үнэн гэсэн учраас худал байсан ч үнэн.
 - E. Бүхий л амьтан ургамал, үзэгдэл юмс ганц.
10. “Олонх түүнийг үнэн гэсэн учраас худал байсан ч үнэн” өгүүлбэрийг тонгоргон хувиргасан нь аль вэ?
- A. Түүнийг бүгд үнэн гэсэн учраас худал байсан ч үнэн.
 - B. Олонх түүнийг үнэн гэсэн учраас үнэн.
 - C. Олонх түүнийг үнэн гэж үзсэн учраас худал байсан ч үнэн.
 - D. Түүнийг олонх үнэн гэсэн учраас худал байсан ч үнэн.
 - E. Түүнийг олонх үнэн гэж үзсэн учраас худал байсан ч үнэн.
11. “Аливаа амьтан ургамал нь ганц ганц учраас ганцаардлын айдастайгаар **төрдөг**” өгүүлбэр дэх тодруулсан үгийг солин найруулахад тохиромжтой нь аль вэ?
- A. үүсдэг
 - B. ирдэг
 - C. эхэлдэг
 - D. амьдардаг
 - E. мэндэлдэг
12. Доорх нийлмэл өгүүлбэрийн онцолсон хэсэг ямар өгүүлбэр болох вэ?
“Их тоонд захирагддаг болсноор тоо олшрохыг хөгжил юм” гэж үздэг.
- A. тодотгол гишүүн өгүүлбэр
 - B. байц гишүүн өгүүлбэр
 - C. өгүүлэгдэхүүн гишүүн өгүүлбэр
 - D. шууд бус тусагдахуун гишүүн өгүүлбэр
 - E. шууд тусагдахуун гишүүн өгүүлбэр
13. “Тэр цагт нэг гэдэг ертөнцийн аугаа их тоо үгүй болно” өгүүлбэрийг асуух утгатай болгож, зөв бичсэн нь аль вэ?
- A. Тэр цагт нэг гэдэг ертөнцийн аугаа их тоо үгүй болбол яах вэ?
 - B. Тэр цагт нэг гэдэг ертөнцийн аугаа их тоо үгүй болбол яахуу?
 - C. Тэр цагт нэг гэдэг ертөнцийн аугаа их тоо үгүй болбол яах бэ?
 - D. Тэр цагт нэг гэдэг ертөнцийн аугаа их тоо үгүй болбол яахав?
 - E. Тэр цагт нэг гэдэг ертөнцийн аугаа их тоо үгүй болбол яахбол?
14. “дагуул үг+цөм үг” гэсэн бүтэцтэй холбоо үгийг олоорой.
- A. галуу шувуу
 - B. ус урсах
 - C. ус мөрөн
 - D. зээрд морь
 - E. бор хоног



15. Хам холбохын “–н” нөхцөлөөр холбогдсон холбоо үгийг олоорой.
 А. удаан алхах В. гурван гол С. ярьсан сэдэв
 D. мөнгөн өвөл E. дүрслэн ярих
16. “дуртай” гэдэг үг үгсийн аймгийн хувьд аль хэсэгт багтах вэ?
 А. зураг, цэцэг, хоол, хичээл В. дурласан, хайрласан
 С. өрөвч, ухаалаг, хүнлэг D. өглөө, шөнө, орой, үдэш
 E. учраас, болохоор, бөгөөд
17. Төрөл үгээс бүрдсэн хэсгийг олоорой.
 А. хиймэл, хийц, хийл, хийлч, хийс
 В. хянуур, хянамгай, хяналт, хянагч
 С. ургац, ургамал, ургацаг, урлаг
 D. холбоо, холбоц, холбогч, холигч
 E. хөгжил, хөгжөөн, хөгшин, хөгжим
18. Хэлц үгээс бүтсэн хэсгийг сонгоорой.
 А. цагаан цэцэг, ногоон тал В. зээрд морь, цагаан сэтгэл
 С. цагаан шөнө, хангай говь D. бараан өдрүүд, хар санаа
 E. үүлтэй тэнгэр, үүлэн борлог
19. Ойрад нутгийн аялгууны “жирглнт” хэмээх үгийг халх аялгуунд зөв буулгасныг олоорой.
 А. жаргалант В. жаргалаа С. жиргээт D. жиргэлээ E. зургаат
20. Бүтээврийн нийлцийг ажиглаад, ялгаатай үгийг олоорой.
 А. хөнгөвчил В. нарийвчил С. бүдүүвчил D. хурдавчил E. амгайвчил
21. Үгсийг утгаар нь зөв харгалзуулсныг олоорой.
 1. тарх а. мэдрэлийн төв эрхтэн
 2. тархи b. бутрах, сарних
 3. тарах с. дэлгэрэх, түгэх
 А. 1а, 2с, 3b В. 1с, 2b, 3а С. 1а, 2b, 3с D. 1с, 2а, 3b E. 1b, 2а, 3с
22. Адил дүрмээр бичсэн үгсийг олоорой.
 А. уяя, наая В. оёё, дурсъя С. ирлэе, өрье
 D. олъё, сольё E. танья, ирье
23. Цэгийн оронд утга тохирох үгсийг сонгоорой.
 “Ёс дагах ёстой” гэсэн санааг
- А. уламжлаа, уламжиллаа В. уламжиллаа, уламжлалаа
 С. уламжлалаа, уламжиллаа D. уламжлаа, уламжлалаа
 E. уламжлалаа, уламжлаа
24. Ч.Лодойдамба “Тунгалаг тамир” романы дараах хэсгээс түүхийн хам сэдвийг илтгэх үг хэллэгийг олоорой.
 Олноо өргөгдсөний дөтгөөр оны зуны эхэн сарын нэгэн өдөр Их Тамирын хойгуур гарсан замаар гуч орчим насны хар хүн нэлээд ачаатай морин тэрэг хөтлөөд явж байв.
 А. зуны эхэн сарын нэгэн өдөр В. олноо өргөгдсөний дөтгөөр он
 С. Их Тамирын хойгуур гарсан зам D. гуч орчим насны хар хүн
 E. ачаатай морин тэрэг хөтлөөд
25. Ч.Лодойдамба “Тунгалаг тамир” романы дараах хэсэгт Эрдэнийн ямар зан чанар илэрч байна вэ?
 Эрдэнэ бусад хүн шиг амьдарч болох байсан ч шинээр ширээ залгасан засаг хаан Гомбожавын зан авир ширүүн, ард олныг зовоох нь хэр хэмжээнээс хэтрэхэд чуулган дарга, монгол манж зургааныг дамжин заргалдав.
 А. үнэнч итгэлтэй В. заргач шүүмжлэгч С. сайхан сэтгэлтэй
 D. шударга зарчимч E. өглөгч өгөөмөр



26. Ч.Лодойдамба “Тунгалаг тамир” романы доорх орчин нөхцөл нь Эрдэнэд хэрхэн нөлөөлсөн бэ?

Эрдэнийн өөрийн хувьд гэвэл багадаа Доной тайжийн хонь хариулж, хурдан морийг нь унаж байхдаа хүү Чулууны нь бичиг заалгахын далимаар бичиг сурч...	“Оюун түлхүүр”, “Алтан товч”-оос эхлэн, олдсон юм бүхнийг уншин, гуйсан хүнд өргөдөл захиа бичиж, удалгүй “Бичээч Эрдэнэ” гэж нутагтаа алдаршжээ.
---	---

- A. хонь хариулдаг болсон B. хурдан морь унаж сурсан
C. хүнд тусалдаг болсон D. нутагтаа алдаршсан E. бичиг үсэгтэй болсон
27. С.Дашдооров “Бууж мордох хорвоо” өгүүллэгийн “Өвгөнийг хөдөөлүүлэхэд газар газраас бишгүй хүн ирж, ах дүү үр хүүхэд нь цөмөөрөө л байж байна” гэсэн хэсгээс илрэх санааг олоорой.
- A. Ангааг буянтай хүн байсныг харуулсан.
B. Ах дүү, найз нөхөд олонтойг харуулсан.
C. Нутаг усандаа алдартай байсныг харуулсан.
D. Нутаг ус нь аятай сайхан газар байсныг харуулсан.
E. Ангааг элбэг дэлбэг амьдарсан хүн гэдгийг харуулсан.
28. С.Дашдооров “Бууж мордох хорвоо” өгүүллэгээс үндэсний ижилсэл буюу монгол хүний зан заншил, сэтгэл зүйн өвөрмөц онцлогийг илэрхийлсэн хэсгийг олоорой.
- A. Хоногийн дараа үд хэвийж байхад Самбаа ирлээ.
B. Газар газраас ах дүү, үр хүүхэд нь цөмөөрөө ирлээ.
C. Энэ л зэрэглээ наадсан талд төрж, эрийн цээнд хүрсэн.
D. Түүний замд халуун хошуут мал таарсан нь ажил бүтэхийн шинж.
E. Төгөөгийнхөөс хоёр зузаан гүвээ давах нь хагас өртөө зайтайн шинж.
29. С.Дашдооров “Бууж мордох хорвоо” өгүүллэгт: Төгөө өвгөний “Хүн өөрсдөө мэдэхгүйгээс биш бие биедээ хэчнээн өртэй байх юм бэ дээ” гэж хэлсэн нь ямар утгыг агуулж байна вэ?
- A. Хүмүүс бие биедээ өртэй байдгийг
B. Хүмүүс нэгэндээ өртэйгөө мэддэггүйг
C. Хүний дурсамж санаашралыг
D. Хүний сэтгэл хөдлөлийг
E. Хүний тусыг санаж явдгийг
30. “Хайку” төрлийн шүлгийг олоорой.
- A. Жин үдийн гэрлийг шөнө дөлөөр ч олж харах
Жимс шарилж хоёрын жинхэнэ амтыг ялгах
Жирийн бус амьдралд хараатай л яваасай билээ.
- B. Эзэд ноёд энд хоргой торгонд хөлбөрч байсан
Эднүүст элч нар хар хурдаараа ирдэг байсан
Өдгөө энэ бүхэн баларч, нурсан балгасны ормон дээр
Өнчин хөхөө ганцаараа гүүг гүүг донгодно.
- C. Алжаан ядрах цагт уулсын оргил түшин амсхийгээрэй
Ангах цангах цагт нуур голоос ундлан шамдаарай.
- D. Мөчрөөс мөчирт
Мөлхөн урсах нь
Хаврын бороо ажээ.
- E. Нүдэнд торох бараагүй
Нуурын ус цэнхэртэнэ
Нүцгэн уулс чимээгүй
Өнгөн дээр нь сүүдэртэнэ.



31. Өгүүлбэрийг зөв уншсаныг олоорой.

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠪᠢᠴᠢᠭ ᠪᠣᠯ ᠰᠡᠶ᠋ᠣᠯᠢᠨ ᠲᠦ᠋ᠭᠦᠬᠡᠨ ᠤᠯᠠᠮᠵᠢᠯᠠᠯᠢᠭ ᠳᠠᠨ ᠠᠪᠴᠢ ᠶ᠋ᠢᠳᠠᠭ.
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠪᠢᠴᠢᠭ ᠪᠣᠯ ᠰᠡᠶ᠋ᠣᠯᠢᠨ ᠲᠦ᠋ᠭᠦᠬᠡᠨ ᠤᠯᠠᠮᠵᠢᠯᠠᠯᠢᠭ ᠲᠡᠭᠨᠡᠨ ᠠᠪᠴᠢ ᠶ᠋ᠢᠳᠠᠭ.
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠪᠢᠴᠢᠭ ᠪᠣᠯ ᠰᠡᠶ᠋ᠣᠯᠢᠨ ᠲᠦ᠋ᠭᠦᠬᠡᠨ ᠤᠯᠠᠮᠵᠢᠯᠠᠯᠢᠭ ᠳᠠᠭᠠᠨ ᠠᠪᠴᠢ ᠶ᠋ᠢᠳᠠᠭ.
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠪᠢᠴᠢᠭ ᠪᠣᠯ ᠰᠡᠶ᠋ᠣᠯᠢᠨ ᠲᠦ᠋ᠭᠦᠬᠡᠨ ᠤᠯᠠᠮᠵᠢᠯᠠᠯᠢᠭ ᠲᠠᠬᠢᠨ ᠠᠪᠴᠢ ᠶ᠋ᠢᠳᠠᠭ.
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠪᠢᠴᠢᠭ ᠪᠣᠯ ᠰᠡᠶ᠋ᠣᠯᠢᠨ ᠲᠦ᠋ᠭᠦᠬᠡᠨ ᠤᠯᠠᠮᠵᠢᠯᠠᠯᠢᠭ ᠲᠡᠭᠡᠨ ᠠᠪᠴᠢ ᠶ᠋ᠢᠳᠠᠭ.

- A. Монгол бичиг бол соёлын түүхэн уламжлалыг даан авч явдаг.
- B. Монгол бичиг бол соёлын түүхэн уламжлалыг тэгнэн авч явдаг.
- C. Монгол бичиг бол соёлын түүхэн уламжлалыг даган авч явдаг.
- D. Монгол бичиг бол соёлын түүхэн уламжлалыг тахин авч явдаг.
- E. Монгол бичиг бол соёлын түүхэн уламжлалыг тээн авч явдаг.

32. Холбоо үгийг зөв уншсаныг олоорой.

ᠬᠡᠭᠡᠷᠦᠨᠭᠦᠢ ᠬᠦᠭᠦ

- A. хөөрөнгүй хүү
- B. хөөрөх хөө
- C. хөөрхий хүү
- D. хөөрхий гүү
- E. хөөрхөн гүү

33. “илт” хэмээх үгийг зөв бичсэн нь аль вэ?

A.

ᠶᠢᠯᠲᠤ

B.

ᠶᠢᠯᠲᠤᠭ

C.

ᠶᠢᠯᠲᠦ

D.

ᠶᠢᠯᠲᠦᠭ

E.

ᠶᠢᠯᠲᠦ

34. Галигийг үндэсний бичигт зөв буулгасныг олоорой.

“Эхэ хэлэн-ү арбин байан санг”

A.

ᠡᠬᠡ ᠬᠡᠯᠡᠨ ᠦ ᠠᠷᠪᠢᠨ ᠪᠠᠶᠠᠨ ᠰᠠᠩᠭᠡ

B.

ᠡᠬᠡ ᠬᠡᠯᠡᠨ ᠦ ᠠᠷᠪᠢᠨ ᠪᠠᠶᠠᠨ ᠰᠠᠩᠭᠡ

C.

ᠡᠬᠡ ᠬᠡᠯᠡᠨ ᠦ ᠠᠷᠪᠢᠨ ᠪᠠᠶᠠᠨ ᠰᠠᠩᠭᠡ

D.

ᠡᠬᠡ ᠬᠡᠯᠡᠨ ᠦ ᠠᠷᠪᠢᠨ ᠪᠠᠶᠠᠨ ᠰᠠᠩᠭᠡ

E.

ᠡᠬᠡ ᠬᠡᠯᠡᠨ ᠦ ᠠᠷᠪᠢᠨ ᠪᠠᠶᠠᠨ ᠰᠠᠩᠭᠡ

35. “-сан⁴” нөхцөлийг залгасан зүй тогтлыг ажиглаад, тохирох үгийг олоорой.

ᠰᠠᠨᠰᠠᠨᠢ
ᠰᠠᠨᠰᠠᠨᠢ
.....

A.

ᠰᠠᠨᠰᠠᠨᠢ

B.

ᠰᠠᠨᠰᠠᠨᠢ

C.

ᠰᠠᠨᠰᠠᠨᠢ

D.

ᠰᠠᠨᠰᠠᠨᠢ

E.

ᠰᠠᠨᠰᠠᠨᠢ

36. “найз” гэсэн үгийг хамаатуулах нөхцөлөөр зөв хувилгасныг олоорой.

A.

ᠨᠠᠶᠢᠵᠢ

B.

ᠨᠠᠶᠢᠵᠢ

C.

ᠨᠠᠶᠢᠵᠢ

D.






ᠨᠠᠶᠢᠵᠢ

E.






ᠨᠠᠶᠢᠵᠢ













37. Олноороо үйлдэх утга илэрхийлсэн үгийг олоорой.

- A.  B.  C.  D.  E. 






38. “үйл үндэс + цагаар төгсгөх нөхцөл” гэсэн бүтэцтэй үгийг олоорой.

- A.  B.  C.  D.  E. 

39. “эх” хэмээх үгийг утгаар нь зөв ялгасныг олоорой.

- A.   B.   C.   D.   E.  

40. “барометр” хэмээх үгийн зөв бичлэгийг олоорой.

- A.  B.  C.  D.  E. 



ХОЁРДУГААР ХЭСЭГ**Санамж:**

- Энэ хэсэг нь 4 даалгавар, нийт 20 оноотой.
- Сонгох даалгавар биш тул харгалзааг зөв тогтоож, тохирох хариуг будаарай.
- Зөв харгалзуулсан хариулт бүр 1 оноотой.

2.1. Жишээ өгүүлбэрийг нэр томьёотой нь зөв харгалзуулаарай. (a, b, c, d, e мөр бүрд нэг хариулт тааруулаарай. 1, 2, 3 тоон дээр байгаа нэр томьёо давхцаж болно)

- | | |
|--------------------------------|-------------------------------------|
| a. Тэнгэр хөмрөх мэт дуугарна. | |
| b. Гол мөрөн үерлэнэ. | 1. Хоёр бүрэлдэхүүнт цөм өгүүлбэр |
| c. Тэнгэр хангай бороо дуудна. | 2. Гурван бүрэлдэхүүнт цөм өгүүлбэр |
| d. Тэр дуун их шуургыг хүсжээ. | 3. Цөм бус өгүүлбэр |
| e. Шувууд нуураа санана. | |

2.2. “Жангар” туулийн жишээг дүрслэх ур маягтай нь зөв харгалзуулаарай.

- | | |
|---|--------------|
| a. Арван тавны сар мэт
Мандаж суудаг болно. | 1. ихэсгэл |
| b. Тахийгаад суухаараа
Хорин таван хүний зайд суудаг | 2. юмшуулал |
| c. Алтан торлог байшин нь
Дугтуй дотор байхлаараа | 3. тойруулал |
| d. Өл манхан цагаан уул нь
Өндөр хөх тэнгэрийн түшиг болох | 4. адилтгал |
| e. Эд мэт эрс нь
Энгийн олон баатартайгаа | 5. багасгал |

2.3. Жишээ үгсийг холбогдох дүрэмтэй нь зөв харгалзуулаарай.

- | | |
|---------------|--|
| a. Дондог+ийг | 1. Үгийн үндэс эвдрэх тул балархай эгшгийг гээхгүй бичих үг |
| b. анар+ыг | 2. Эгшигт гийгүүлэгчийг эгшигжүүлэх үүрэгтэй балархай эгшгийг гээхгүй бичих үг |
| c. самбар+ыг | 3. Урт эгшгээр эхэлсэн нөхцөл залгахад ялгах эгшгийг гээхгүй бичих үг |
| d. эрин+ийг | 4. Оноосон нэрийн балархай эгшгийг гээхгүй бичих үг |
| e. төлөв+ийг | 5. Уламжлалын зарчмыг баримтлан балархай эгшгийг гээхгүй бичих үг |

2.4. Үгсийг дүрсээр ялган, зөв тохируулаарай. (a, b, c, d, e мөр бүрд нэг хариулт тааруулаарай. 1, 2, 3, 4 тоон дээр байгаа үгс давхцаж болно)

- | | | | | |
|-------------------|----|----|----|----|
| a. дэм (тус) | 1. | 2. | 3. | 4. |
| b. там (диваажин) | | | | |
| c. дам (яриа) | | | | |
| d. хайр (нэр үг) | | | | |
| e. хайр- (үйл үг) | | | | |

